

Хангай дээд сургууль

Гадаад харилцаа, хамтын ажиллагааны алба

Тус сургууль нь 2001 онд үүсгэн байгуулагдсан цагаас эхлэн гадаадын их, дээд сургууль, олон улсын байгууллагуудтай идэвхтэй хамтран ажиллаж, туршлага солилцон, өөрийн сургуулийн оюутан, суралцагчдыг гадаадын их дээд сургуулиуд болон байгууллагуудад дадлагажуулах, цалинтай дадлага хийлгэх мөн зарим байгууллагуудад ажиллуулах, бакалавр, магистр, докторын сургалтуудад тэтгэлэгтэйгээр хамруулах, оюутан солилцоо болон дипломын сургалтад хамруулах зэргээр хамтран ажиллаж ирсэн туршлагатай билээ.

Тус сургууль нь 2024-2025 оны хичээлийн жилийн байдлаар 11 орны 62 их, дээд сургууль, коллежуудтай хамтын ажиллагааны гэрээтэй үүнээс гадна Европын холбоо, ЮМАП олон улсын магадлал итгэмжлэгдсэн их сургуулиудын холбоо, Японы хувийн их дээд сургуулиудын холбоо зэрэг холбоонуудтай хамтран ажиллаж, үйл ажиллагаагаа явуулж байна.

2016 онд Монголын хувийн их, дээд сургууль, коллежуудын холбоог байгуулсан бөгөөд уг холбоо нь Японы хувийн их, дээд сургууль, коллежуудын холбоотой хамтран ажилладаг. Уг холбоонд өдгөө 411 их, дээд сургууль, коллежууд хамрагддаг ба эдгээр сургуулиудтай багш, оюутан солилцоо, хамтарсан хөтөлбөр, цалинтай дадлагажигч оюутан зэрэг хөтөлбөрөөр идэвхтэй хамтран ажиллаж байна.

Мөн 2018 онд Европын холбооны их сургуулиудын судалгаа шинжилгээний ур чадварыг сайжруулах Ерасмус плас төсөлд, 2021 онд Европын холбооны Эрчим хүчний хэмнэлтийн төслүүдэд амжилттай хамрагдсан.

2023 онд БМИҮЗ-с санал болгосны дагуу UMAP Ази, Номхон далайн улс орнуудын магадлан итгэмжлэгдсэн их сургуулиудын олон улсын холбоонд нэгдэн орсон.

2024-2025 оны хичээлийн жилээс БНСУ-ын JEIU их сургуультай хамтарсан Хиймэл оюун ухааны 2+2 хөтөлбөр амжилттай хэрэгжиж байна. Мөн цаашлаад бид Унгар улсын Жон вон Нейманы их сургуультай хамтран аялал жуулчлалын хамтарсан хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр ажиллаж байна. Үүнтэй холбоотойгоор БНСУ-ын Хиймэл Оюун Ухааны Эм Эс Кореа болон Жини Эдүтейк компанитай хамтран Хиймэл оюун ухааны HANGAI & MS KOREA SMART CENTER, HJ AIT

CENTER-ийг байгуулсан. Энэхүү төв нь Монгол улсад хиймэл оюун ухааныг өргөн хүрээтэй хөгжүүлэх, аж ахуй нэгж байгууллагуудад хиймэл оюун ухаан, түүнтэй холбоотой программ хангамж, техник технологиудыг таниулах, хөгжүүлэх зорилготой. Энэ үйл ажиллагааны хүрээнд Хангай дээд сургуулийн программ хангамж, хиймэл оюун ухааны багш Б.Нямбаяр нийтэд чиглэсэн захиалгат сургалтуудыг амжилттай хэрэгжүүлж эхлээд байна.

Мөн Хангай дээд сургууль нь БНСУ-ын Комвин, Жиние эдү тэйч, Эм Эс Кория компаниудтай хамтран ажилласнаар Монгол улсын аж ахуй нэгж байгууллагуудад хиймэл оюун ухааны талаар анхан шатны болон ахисан шатны сургалтуудыг зохион байгуулах, тоног төхөөрөмжүүдийг нийлүүлэх, суралцагчдыг БНСУ-д дадлагажуулах, сургалтад хамруулах боломжууд бүрдсэн. Эрдэм шинжилгээний чанарыг сайжруулах, хамтарсан төсөл хэрэгжүүлэх зорилгоор “Эрдэм шинжилгээ, судалгаа инновацын төв”-ийн дэргэд БНСУ-ын КОМВИН ХХК-тай хамтран “Компьютер засварын төв” байгуулсан. Цаашлаад БНСУ-ын Next Form ХХК-тай хамтран K-pass хамтарсан төслийг хэрэгжүүлэхээр ажиллаж байна. Эдгээр төслүүдэд Хангай дээд сургуулийн хиймэл оюун ухаан, программ хангамж, график дизайн ангийн багш, оюутнууд хамтран оролцож, төслийг хэрэгжүүлнэ.

Үүнээс гадна тус сургууль нь 2025 оны 01 сараас эхлэн Европын холбооны санхүүжилттэй RETEACH буюу “Монгол улсын багш бэлтгэх боловсролыг ногоон болон дижитал шилжилт рүү шинэчлэн нэвтрүүлэх нь” төсөлд хамрагдаж багш бэлтгэх хөтөлбөрийг ногооруулах, цахим болгох чиглэлээр төслийн багт амжилттай хамрагдаж байна, төслийн үр дүнд багш бэлтгэх хөтөлбөрүүдийг шинэчлэн сайжруулж байгальд ээлтэй, ирээдүйн суралцагчдын эрэлт хэрэгцээнд нийцсэн ногоон болон цахим хөтөлбөрийг бий болгож цаашлаад улсын хэмжээнд тухайн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх томоохон төсөл юм. Уг төслийн санхүүжилтээр тус сургууль нь 2025-2026 оны хичээлийн жилд багшийн хөгжлийн төв, Багш ангийн суралцагчдад зориулсан орчин үеийн өндөр үзүүлэлт бүхий компьютерын лабораторийг тохижуулан, сургалтад ашиглах, төслийн багийн гишүүд багшийн мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдах зэрэг олон дэвшилтүүд гарах юм.







